

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.020.40

Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага	MNS 6141 : 2010
Seedlings of deciduous trees. Technical requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2010 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь ойт хээр, хээрийн бүсэд орших хот, суурин газрын ногоон байгууламж, талбай хамгаалах ойн зурвас (хус, улиас, улиангар), цөл, цөлөрхөг хээрийн бүсийн ойжуулалт, ойн зурвас, хот суурин газрын ногоон байгууламжид (тоорой, жигд, агч, хайлаас, ледебурын бургас), зориулан мод үржүүлгийн газарт бойжуулсан болон ойгоос авах суулгацыг сонгон ухаж авах, хамгаалах, савлах, тээвэрлэх, суулгах, шалгаж хүлээн авахад хамаарна.

2 Техникийн шаардлага

2.1 Навчит төрлийн модны суулгацын зэрэг тус бүр нь 1-р хүснэгтэд дурьдсан шаардлагыг хангасан байна.

2.2 Навчит модны суулгацын үндэс болон салаалсан мөчрүүдийг доороос өөд нь шуухдаа холтосны гадаргаас 5-аас 10 мм-ээс илүүгүй хэмжээнд огтлож үлдсэн ёзоорыг тосон будгаар будаж, өвчлөх, хөнөөлт шавжид нэрвэгдэхээс сэргийлэхийн зэрэгцээ, нарны гэрлийн хэт цонолтоос хамгаалж шохойгоор будсан байна.

2.3 Ойгоос буюу мод үржүүлэх талбайгаас суулгацыг авахдаа урд зүг буюу нар харсан талд нь (даавуу, утас уях зэрэг) тэмдэг тавьсан байна.

Д/д	Үзүүлэлт	Хэмжээ ба шаардлага		
		1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг
0	1	2	3	4
1	Гадаад байдал	Гадна талын байдал, өнгө хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин, хөнөөлт шавьжид нэрвэгдээгүй, нахиа нь задраагүй, уян зөөлөн саглагар мөчиртэй, иш нь бүдүүвтэр, эгц шулуун, бат бөх үндэс ихтэй, өсөлт сайтай байна.	адил	адил
2	Хэлбэр	Зөв титэмтэй, мөчир нь хугараагүй, салаалсан мөчрүүд нь ишний нийт уртын 2/3-г эзэлсэн байна.	адил	адил
3	Хэмжээ:			
	а. Үндсэн мөчрийн тоо	10-13	8-10	7-8
	б. Титмийн тэлэлтийн голч метрээр	1,6-2,0	1,2-1,5	0,8-1,0
	в. Суулгацын өндөр, метрээр:			
	Хус	0,7 ба дээш	0,5-0,7	0,4-0,5
	Улиас	1,5 ба дээш	1,0-1,5	0,8-1,0
	Улиангар	1,5 ба дээш	1,0-1,5	0,8-1,0
	Тоорой	0,8 ба дээш	0,6-0,8	0,4-0,6
Жигд	0,8 ба дээш	0,6-0,8	0,4-0,6	
Ледебурын бургас	1,2 ба дээш	0,8-1,2	0,6-0,8	
Агч	1,0 ба дээш	0,7-1,0	0,5-0,7	
Хайлаас	0,8 ба дээш	0,6-0,8	0,4-0,6	
4	Үндэс:	Өсөлт хөгжилт сайтай, 3-аас доошгүй бүдүүн үндэстэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой нь хамт авна.	адил	адил
	а. Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн голч, метрээр	1,2-1,5	1,1-1,2	0,9-1,0
	б. Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн зузаан метрээр	0,50-0,55	0,45-0,50	0,40-0,45

2.4 Үндэстэй нь хамт авсан шорооны чийгийг алдагдуулж болохгүй.

2.5 Суулгацыг газар гэссэний дараа 4-р сарын 20-оос 5 дугаар сарын 25-ны дотор, ургалт зогссоны дараа 10-р сарын 1-ээс 11-р сарын 1-нийг хүртэл тус тус суулгасан байна.

2.6 Суулгацыг байрлуулах нүхний голч ба гүнийг энэ стандартын хүснэгтийн 4 а ба 4 б зүйлийн дагуу зэрэг тус бүрд заагдсан хэмжээгээр бэлтгэх ба ёроолд нь үржил шимтэй хар шороог 20-оос 25 см-ээс доошгүй зузаантайгаар голд нь шовойлгож асгасан байна. Суулгацыг байрлуулсаны дараа хар шороогоор сайн чигжиж, ханатал услах ба эгц ургуулахын тулд гувар ба титэмийн уулзварт даавуу буюу шуудайгаар мөчир үйс, холтсыг нь гэмтээхгүйгээр 1 см-ээс доошгүй зузаан, 5 см өргөн даавуу шуудайгаар зөөллөн ороож төмөр утас буюу олсоор 3 зүгт тэлэн татаж бэхэлнэ.

3 Суулгацыг хүлээн авах

3.1 Нийлүүлэгчээс хүлээн авах суулгацын чанарыг энэ стандартын шаардлагын дагуу нэг бүрчлэн шалгаж хүлээн авна.

3.2 Суулгацын чанар нь стандартын шаардлага хангахгүй бол нийлүүлэгчээс хүлээн авахыг зөвшөөрөхгүй.

3.3 Хэсэг бүхэнд суулгацын паспорт дагалдах ёстой. (Паспортын агуулга нь хавсралт маягтын дагуу хийсэн байна)

4 Хадгалах, савлах, тээвэрлэх

4.1 Суулгацын шороотой хэсгийн өөрийн чийгийг алдагдуулахгүйгээр нүх, шуудуунд хийж хадгалах бөгөөд хөлдөх, ууршихаас хамгаалж малын бууц, хар шороогоор хучсан байвал зохино.

4.2 Энэ стандартын хүснэгтийн 4а ба 4б зүйлд зааснаар суулгацын үндэс, шороотой хэсгийг шуудай буюу модон хайрцагт хийж савлана.

4.3 Суулгацыг авто машинаар тээвэрлэхэд нэгдүгээр зэргийг нэг машинд 1-ээс 2 ширхэг, 2 дугаар зэргийг 10-аас 15 ширхэг, 3 дугаар зэргийг 20 ширхэгээс дээшгүйгээр тус тус ачина. Ачихдаа машины тэвшний ёроолд 40-аас 50 см үртэс эсвэл 25-аас 30 см зузаантай хар шороо, малын бууц, дэвсэж зөөллөнө. Тээвэрлэхдээ үндсийг хучиж, усалж тээвэрлэнэ. Суулгацыг суулгах хүртэлх хугацаанд тогтмол чийгтэй байлгана. Нэгдүгээр зэргийн суулгацын үндэстэй талыг нь жолоочийн бүхээг рүү харуулж хэвтүүлээд суулгацын үзүүрийн дамнах хэсгийг 5 см-ээс доошгүй зузаантай зориулалтын материалаар зөөллөж тээвэрлэнэ.

4.4 Авто машинд 2 ба 3 дугаар зэргийн суулгацыг хооронд нь хавиралдуулахгүйгээр босоо байдлаар ачиж мөн дээрхийн адил тэвшний ёроолд зөөлөвч дэвсэж ачина.

4.5 Суулгацыг авах, суулгахдаа агротехникийн шаардлагыг баримтална.

4.6 Суулгацын хэсэг бүхэнд хавсралтад дурьдсан паспортыг дагалдуулна.

ТӨГСӨВ.

**ХАВСРАЛТ
/Норматив/**

ПАСПОРТЫН №

Суулгацын нэр _____

(суулгацын төрөл, зүйл, нас, хэсэг дэх ширхэг)

Өгсөн _____

(мод үржүүлгийн газар, ойгоос)

1. Чанарын үзүүлэлтүүд

Суулгацын чанарын анги	Суулгацын техникийн нөхцөл буюу стандартын нэр ба дугаар	Суугацын тоо	
		ширхэгээр	Бүх хэсэг дэх %
I			
II			
III			

Суулгацыг ухаж авсан хугацаа

явуулсан хугацаа

Ой хамгаалагчаас суулгацыг явуулахыг зөвшөөрч олгосон баримт

(ой хамгаалагчийн нэр.....он,.....сар,.....өдөр№)

2. Гарал

Суулгац сонгон авсан газар (мод үржүүлгийн газар, аймаг, сум, газрын нэр)

Паспорт № суулгацыг хэн хэдийд өгсөн

3. Ургуулах нөхцөл

Мод үржүүлгийн газрын нэр ба орших газар:

Мод үржүүлгийн газрын хөрс

Суулгацын өвчин, хорлогчдод нэрвэгдсэн байдал ба цаг уурын нөлөөллийн тухай тэмдэглэл

Паспорт олгосон онсар өдөр

Аж ахуйн удирдагч

Мэргэжилтэн.....

20... оны ... дугаар сарын ...-ний өдөр